

Монгол дахь Офисын Ажилтнуудын зохицуулалтын журмын 11-р хавсралт

Зан байдлын дүрэм

Каритас Чех Републикийн Монгол дахь төлөөлөгчийн газрын ажилтнуудад хамааралтай

I. Оршил:

- a. Энэхүү Зан байдлын дүрмээр Монгол дахь КЧР-ийн бүх ажилтнуудын дагавал зохих хандлага, зан үйлийг тодорхойлсон болно. Энэ дүрэм нь КЧР-ийн байгууллагуудын суурь үнэт зүйлс, институт практик дадлыг тодорхойлсон КЧР-ийн Ёс зүйн дүрмээс үүдэлтэй бөгөөд үүнтэй нягт холбоотой юм.
- b. “Хэрэгцээ бүхий хүмүүст анхаар халамжлан тавьдаг хүмүүс нь эхлээд өөрсдөө мэргэжлийн хувьд чадварлаг байх ёстой: тэд юу хийх, хэрхэн яаж хийх талаар сургагдсан байх ёстой бөгөөд үргэлжлүүлж халамжл тавих тал дээр шийдэмгий байна. Гэсэн хэдий ч, мэргэжлийн ур чадвар нь анхдагч, үндсэн шаардлага боловч энэ нь дангаар хангалттай биш юм. Бид хүмүүстэй харьцаж ажилладаг бөгөөд хүмүүст холбогдох техник халамжаас илүү их зүйл хэрэгтэй байдаг. Тэдэнд хүмүүнлэг хандлага хэрэгтэй байдаг юм. Тэдний төлөө чин сэтгэлээсээ санаа зовох хэрэгтэй байдаг.”

II. Зан байдлын дүрэм

- a. Энэхүү Дүрмийг ашиглах ньхялабар байхын тулд үндсэн дөрвөн хэсэгт хуваасан болно.
- b. КЧР-ийн бүх ажилтнууд дараах удирдамжийг дагаж мөрдөх ёстой:
 - i. Үнэт зүйлс, Зан байдал ба Ёс зүй
 1. КЧР-ийн нийгмийн болон ёс суртахууны үнэт зүйлсийг дагаж мөрдөх, эсхүл ядаж ойлгож, хүндэтгэх
 2. тэдний хувийн болон мэргэжлийн зан байдал нь хамгийн өндөр жишиг стандартад нийцсэн болохыг үргэлж хангах ба тэгж харагддаг байх
 3. олон төрлийн байдлыг тэмдэглэх хүрээлэн буй орчинг бүрдүүлж, чин сэтгэлээсээ ажиллаж, бусад хүмүүстэй нэр төртэй, хүндэтгэлтэй харьцдаг байх
 4. хүний эрхийг бүхэлд нь хүндэтгэж, бусдын эрхийг зөрчсөн ялгаварлан гадуурхах, дарамтлах, хүчирхийлэл, үл тоомсорлох, мөлжлөг зэргийг эсэргүүцдэг байх

5. арьс өнгөөр ба эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан шинжтэй, эсхүл бусад хэлбэрээр олон нийтэд эсхүл хувийн журмаар доромжилсон мэдэгдэл хийхээс зайлсхийх
 6. бусдыг хор хөнөөлөөс хамгаалах зохих арга хэмжээ авдаг байх
 7. ухамсрынхаа хүрээнд ажиллаж буй улс орныхоо хууль тогтоомжийг дагаж мөрддөг байх
 8. орон нутгийн зан заншил, соёлыг хүндэтгэдэг, мэдрэмтгий байх, зохих ёсоор хувцаслах
 9. өөрсдийгөө болон удирддаг ажилтнуудаа эрүүл ахуй, аюулгүй байдал ба аюулгүй байдлын удирдамжийн дагуу ажиллахыг
 10. хангаж, бусдыг хамгаалах талаар хичээдэг байх
 11. КЧР-ийн нэр хүндийг гутаахгүй байх нөхцөлийг хангадаг байх
 12. КЧР-т ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан аливаа мэдээлэл, мэдлэгийн нууцлалыг хадгалах
 13. үүрэг хариуцлагыг чадварлаг, хайраар хандаж гүйцэтгэх, аливаа хэлбэрийн гадуурхал, ялгаварлан гадуурхалгүй хандаж, КЧР-ийн ядуу хүмүүсийг давуу эрхтэйгээр авч үзэх сонголтыг хадгалах
 14. өөрсдийн итгэл үнэмшлээ илэрхийлж, хэрэгжүүлэхдээ орон нутгийн эмзэг онцлогийг санадаг байх
 15. КЧР-ийн бусад байгууллагуудаас ирсэн хүмүүсийг найрсаг угтан авч, эв нэгдэл, хамтын ажиллагааг бэхжүүлдэг байх
- ii. Ашиг сонирхлын зөрчил, хавчлага дарамт, авлига
1. КЧР-ийн ажилтны үүрэг гүйцэтгэх эрх мэдэл бүхий албан тушаалыг ашиглахдаа
 2. дарамт шахалт үзүүлэх, эсхүл хувьдаа эдийн засгийн, мэргэжлийн, улс төрийн эсхүл бэлгийн давуу тал олж авахаас зайлсхийх
 3. КЧР-ийн ажилтай холбоотой байж болох эсхүл бодит аливаа (санхүүгийн, хувийн эсхүл гэр бүлийн чанартай) ашиг сонирхлын зөрчлийн талаар удирдагчдаа эсхүл бусад ахлах шатны менежерт бичгээр мэдэгддэг байх
 4. ямар ч тохиолдолд үр шим хүртэгчид, түншүүд эсхүл гэрээт гүйцэтгэгч нараас аливаа таатай нөхцөл, хээл хахууль эсхүл хувьдаа баяжих зүйлийг ямар ч нөхцөлд хүлээн авахаас татгалздаг байх
- iii. Каритас Чех Републикийн өмч хөрөнгийг зохистой захиран зарцуулж, хамгаалах
1. КЧР-ийн актив хөрөнгө, оюуны өмчийг зүй бусаар ашиглахгүй байх бөгөөд хулгай, залилан, бусад хохирлоос хамгаалахыг хангадаг байх
 2. санхүүгийн хариуцлагад үнэнч шударга, шударга шулуун байх холбогдох стандартыг баримтлах
- iv. Хувийн зан байдал
1. амьдрах байр/офис/тээврийн хэрэгсэл зэргийг хамруулан, КЧР-ийн аливаа (эзэмшсэн эсхүл түрээслэсэн) бизнест эсхүл өмч хөрөнгөд зэвсэг авч явахаас зайлсхийх.
 2. тайвшруулах эм, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс зайлсхийх
 3. бэлгийн зан байдлыг үргэлж зохистой байлгах тал дээр асуудалгүй байх

III. Зан байдлын дүрмийн хэрэгжилт

а. Санал гомдлын механизм

- i. Мэдээлэх үүрэг: Энэ дүрмийг зөрчсөн сэжиг бүхий эсхүл санаа зовоож буй асуудлын талаар ажилтан бүр нэн даруй мэдээлэх үүрэгтэй. Ихэнх тохиолдолд ажилтнууд аливаа асуудлын талаар өөрийнхөө даргад хандах ёстой. Үүнийг амаар болон бичгээр үйлдэж болох бөгөөд үүнд бүрэн дэлгэрэнгүй мэдээлэл болон, хэрэв боломжтой бол нотлох баримтын хамт мэдэгдсэн байвал зохино. Хэрэв ямар нэг шалтгаанаар (жишээлбэл, менежер нь холбогдсон байж болзошгүй) ингэх боломжгүй тохиолдолд тэд илүү дээд шатны менежер эсхүл өөр холбогдох эрх мэдэл бүхий этгээдэд хэлэх ёстой.
- ii. Аливаа мэдээллийн нууцыг чанд хадгалана. Ноцтой зөрчлийн талаар асуудал тавьж буй хэн боловч, хэрэв ноцтой асуудлын талаар чин сэтгэлээсээ санаа зовж мэдэгдэж байгаа бол, хохирогч болгох эсхүл түүнд хор хөнөөл учруулахаас хамгаалах болно. Зориудаар худал мэдүүлэг өгөхийг сахилгын ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд шалгаж, зохих журмын дагуу арга хэмжээ авна.

IV. Дүрмийг зөрчсөн тохиолдолд

- a. Зан байдлын дүрмийг зөрчсөн аливаа тохиолдолд шалгалт хийх бөгөөд сахилгын арга хэмжээ авахад хүргэж болно.